

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 08

№	ЗГҮАХ-т тусгагдсан зорилт		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт		Хүрсэн түвшин, үр дүн		Хэрэг жилт хувь
					2022 он	2023 он	Хэрэгжилт	Гүйцэтгэл Эх үүсвэр /сая төг/	
					Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт				
2.5. Хөдөлмөр, нийгмийн хамг аалал. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ									
1	2.5.1.Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ	1	Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	2020-2024	Нийгмийн даатгалын багц хууль батлагдсан байна	Нийгмийн даатгалын эрх зүйн орчин шинэчлэгдэж олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдсэн байна.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжсэнээр олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн даатгалын тогтолцоог хуваарилалтаас хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжүүлэх, хуримтлал үүсгэх, тэтгэврийн даатгалын нэрийн дансны хийсвэр бичилтийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогоос өвлүүлэх зэрэг томоохон өөрчлөлтийг хийх хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн.	100	
		2	Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ	2020-2024	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсан байна.	Иргэд суурь тэтгэвэр авах эрх зүйн очин бүрдсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь иргэн бүрт суурь тэтгэвэр олгох, уг суурь тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн судалгаа, бусад орны суурь тэтгэвэр олгож буй туршлага зэргийг судлан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд иргэн бүрт суурь тэтгэвэр олгохоор хуулийн төслийг боловсруулж намын бүлэг, төрийн болон төрийн бус байгууллагаар хэлэлцүүлэхэд нийгмийн халамжийн тэтгэвэр нь суурь тэтгэвэр тул хасах саналыг ирүүлснээр хуулийн төслөөс хассан болно.	100	

					Харин тэтгэвэр авагч нас барсан бол Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэр бүлээ бүртгүүлсэн, 20 ба түүнээс дээш жил хамт амьдарсан эхнэр, эсхүл нөхрийн тэтгэврийн хэмжээг нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн 20 хувиар нэмэгдүүлэхээр хуулийн зохицуулалтыг нэмж тусгаж батлуулсан.		
3	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ	2020-2024	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын хууль батлагдсан байна.	Иргэд хувийн тэтгэврийн даатгалд даатгуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 1 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Улмаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан 10 аймаг, нийслэлд ахмадууд, залуучууд, сайн дураар даатгуулагчид, үйлдвэрчний эвлэлийн шат шатны байгууллага, ажил олгочдын төлөөлөл, худалдаа аж үйлдвэрийн танхим, хуульчдын холбоо зэрэг газруудаар нийгмийн даатгалын багц хуулийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэн, иргэд олон нийтээс санал авах арга хэмжээг зохион байгуулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин баталсан. Энэ дагуу Ажлын дэд хэсгийн гишүүд хуулийн төслийн санал дүгнэлт боловсруулан ажиллаж байна. Улсын Их Хурлын D parliament цахим хуудсанд хандан 21 дэмжсэн санал, зарим холбогдох хуулийн заалтуудад өөрчлөн найруулах 22 саналыг тус тус ирүүлсэн бөгөөд 17,560 дэмжсэн санал		70

						өгсөн байна. УИХ-ын 2023 оны намрын чуулганаар Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах үүднээс Нийгмийн бодлогын байнгын хорооны дэд ажлын хэсэг 12 удаа хуралдсан. Мөн Улсын Их хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар уг хуулийг хэлэлцсэн.			
2	2.5.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ	1	Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчны хүрээнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ	2020 2024	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх талаарх хуулийн заалт батлагдсан байна.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх талаарх хуулийн заалт батлагдсан байна	Нийгмийн даатгалын ерөнхий, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шатлгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг тус тус 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаар баталсан. Шинэчлэн батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх” харилцааг тусгасан. Тэтгэврийн нөөц санг даатгуулагчийн төлөх шимтгэлийн 2 хувь, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу улсын төсөвт шилжүүлсэн орлого, улсын төсвөөс олгох бусад орлогоос бүрдүүлэхээр хуульчилсан. Тухайлбал, 2024 оноос эхлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2.0 хувийн шимтгэлийн орлогыг хуримтлал болгох арга хэмжээ үе шаттай хэрэгжиж эхлэх бөгөөд 2024 онд 380 орчим тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг мөнгөжүүлэх, энэхүү эх үүсвэрээр тэтгэврийн даатгалын санд олгох улсын төсвийн татаасыг нэмэгдүүлэн батлуулсан. Ингэснээр даатгуулагч боловсрол, эрүүл мэнд, орон сууцны ипотект зарцуулах боломжийг тухайлсан хуулиар зохицуулахаар тусгасан.		100

3	2.5.3.Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.	1	Хуримтлалын нэгдсэн сан бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2020 2022	Хуулийн төслийг батлуулж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	-	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/64 дүгээр тушаалаар Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж хуулийн төслийг боловсруулах чиглэлээр ажлын хэсгийн хурал 3 удаа, хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулсан. Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хооронд Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах, хууль эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр хамтран ажиллах гэрээг 2023 оны 06 сарын 07-ны өдөр байгуулсан. Тус гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Сингапурын хамтын ажиллагааны байгууллагатай 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Монгол Улсын онцлогт нийцсэн Хуримтлалын тогтолцоог бий болгох Хуримтлалын нэгдсэн сангийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд хуулийн төсөл, хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдүүлбэрийн хамт боловсруулсан. Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулан Хуримтлалын нэгдсэн сангийн орлого, зарлагын хэтийн төлвийг тооцох актуар тооцооллыг хийж байна.		70
4	2.5.4.Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс,	1	Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ	2020- 2024	Хуулийн шинэчлэлтэй уялдуулан холбогдох бусад хууль тогтоомж, бусад дүрэм, журамд өөрчлөлт оруулж	Хууль эрх зүйн шинэчлэл хийгдэж үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцооны эрх зүйн үндэс	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлалыг Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудтай уялдуулан шинэчлэх ажлын хүрээнд уг хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран		70

	<p>ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.</p>			<p>батлуулсан байна.</p>	<p>бүрэн бүрдсэн байна.</p>	<p>батлахаар 2023 оны 12 сарын 01-ний өдрийн 01/3132 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Мөн хуулийн төсөл, зардлын тооцоог боловсруулан Засгийн газарт өргөн мэдүүлэхээр бэлэн боллоо.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зохицуулалтыг тусгаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг, урамшуулал олгохоос гадна ажлын байрыг хадгалах, хамгаалах, ялангуяа эдийн засгийн болон бусад давагдашгүй хүчин зүйлийн улмаас бий болдог хямралын үед хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг Ажилгүйдлийн даатгалын тухай болон бусад хууль тогтоомжтой уялдуулан тусгах, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын дийлэнх хэсгийг ажилгүйдлийн даатгалын сангаас бүрдүүлдэг болгоно. - Ажилгүйдлийн даатгалын үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийн бодлогын арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, ажил олгогчийг дэмжих, хүн ам, үүний дотор зорилтот бүлгүүдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр өргөжүүлнэ. - Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай” 122 дугаар конвенцид нийцүүлэн хөдөлмөр эрхлэлт төвтэй хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг ажилгүйдлийн даатгал, нийгмийн халамж, хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, эдийн засаг, нийгмийн бусад бодлоготой уялдуулснаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо шинэчлэгдэж, үйл ажиллагааны үр дүн нэмэгдэнэ; - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих суурь нөхцөлийг бий болгохоор хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн ойрын, дунд, хэтийн хугацааны судалгааг холбогдох аргачлалын дагуу хийж, дүн, мэдээг иргэдэд 		
--	--	--	--	--------------------------	-----------------------------	---	--	--

						<p>түгээх замаар мэргэжил сонголтыг зөв, оновчтой хийх боломжийг дэмжих зохицуулалтыг тусгах,</p> <p>- Хөгжлийн бэрхшээлтэй хүн, залуучууд, эмэгтэйчүүд болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зохицуулалт хийх, дэмжлэгийн төрөл, хэлбэрийг хуульд нарийвчлан тусгах; бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хүрээнд нэр томьёог боловсронгуй болгож, холбогдох дэмжлэг, урамшууллыг оновчтой, уялдаатай, шаталсан байдлаар тодорхойлох, бизнес инкубацийн үйлчилгээг орчин үеийн чиг хандлагад нийцүүлж үзүүлэх зэрэг дэмжлэг, үйл ажиллагааг хуульд тусгасан.</p>		
2	<p>Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний уян хатан зохицуулалт бий болгож, бүтээн байгуулалт, хөдөлмөрийн зах зээлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ</p>	2020-2024	<p>Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний үйл ажиллагаанд цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байна.</p>	<p>Гадаадад ажиллах хүч илгээж буй үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, илгээгч байгууллагуудыг чадавхжуулах арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит чуулганаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хууль энэ оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.</p> <p>Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар зөвхөн хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгохтой холбоотой эрхээ бусдад шилжүүлэх зохицуулалттай тул “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой чиг үүргийг шилжүүлж болох эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх зорилгоор Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.</p> <p>Ингэснээр эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжтэй, шуурхай байдлыг бий болгох гадаадад ажиллах хүч илгээж буй аж ахуйн</p>	90		

					<p>нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахад эерэг үр дүн гарна.</p> <p>“Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл олгох” үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, ezuvshuurul.mn/out цахим систем хөгжүүлэн бүрэн ашиглалтад оруулаад байна. Уг системд 47 тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд болон 3088 зуучлуулагч иргэн бүртгэлтэй байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах” 233 дугаар тогтоолын 1-т “тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг” цахим хэлбэрт шилжүүлэхээр заасан. Уг тогтоолын хэрэгжилтийн хүрээнд “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран 2023 оны 10 дугаар сард бодлогын даалгавар боловсруулсан. Тусгай зөвшөөрлийг “Тусгай зөвшөөрлийн цахим систем–www.license.mn”-д оруулах хөгжүүлэлтийг “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” улсын үйлдвэрийн газраар хийлгэж, ашиглалтад ороход бэлэн болгоод байна.</p> <p>НҮБ-ийн ОУ-ын шилжилт хөдөлгөөний байгууллага болон “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсад хүчин чармайлалтыг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад “Олон улсын хөдөлмөр зуучлалын нэгдсэн системийн ёс зүйтэй хөдөлмөр зуучлал” сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад оролцсон 40 тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон дагаж гарах журмуудын талаар танилцуулсан.</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>Нийгмийн суурь үйлчилгээг үзүүлдэг боловсролын салбарын багш, эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч болон эрүүл мэндийн ажилтнуудын ажлын ачаалал, үр чадвар, мэргэшил, ажлын гүйцэтгэл, үр дүн, ажилласан жил зэргээс хамаарсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. Энэ хүрээнд Засгийн газраас төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн доод хэмжээг баталж, салбарын онцлог, гүйцэтгэлд суурилсан үр дүнг харгалзан үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг цалингийн доод хэмжээнээс нэмэгдүүлэх асуудлыг тухайн жилийн батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд зохицуулж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах эрхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт олгосон. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын зарим төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанар үр дүнг цалин хөлс, урамшуулалтай уялдуулах, аргачлал бий болгох, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх ажлыг 2021 оноос эхлэн хэрэгжүүлж байна. 2023 онд “Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад үр чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам”-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран шинэчлэн боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн А/421, А/115, А/170 дугаар тушаалаар батлуулав. Мөн холбогдох байгууллагуудаас боловсруулан санал авахаар ирүүлсэн “Төсвийн байгууллагын нягтлан бодогчид үр</p>	
3	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанарыг цалин хөлс, урамшуулалтай уялдуулах	2021-2024	Урамшууллын ажлын үр дүнтэй уялдуулах аргачлалыг нэвтрүүлж, холбогдох журмыг хэрэгжүүлнэ.	Урамшууллын ажлын үр дүнтэй уялдуулах аргачлалыг нэвтрүүлж, холбогдох журмыг хэрэгжүүлнэ	100	

					<p>чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт” батлах тухай хамтарсан тушаалын төсөл, “Журам шинэчлэн батлах тухай” /Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам, ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт/ хамтарсан тушаалын төсөлд санал боловсруулан хүргүүлэв.</p> <p>Түүнчлэн төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг нэгдсэн хуулиар зохицуулах, цалин хөлсийг гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулах чиглэлээр боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, шинжлэх ухаан, төрийн тусгай болон төрийн захиргааны албан хаагч гэсэн 6 бүлэгт ангилал тус бүрийн төлөөллүүдийг оролцуулан фокус группын ярилцлагыг 2023 оны 5 дугаар сард зохион байгуулсан. Уг ярилцлагын үр дүн, төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой одоогийн нөхцөл байдал, цаашид төрийн албан хаагчдын цалин хөлсийг гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулах, нэмэгдлийн хэмжээг хязгаарлах зэрэг арга хэмжээний саналыг боловсруулан Ерөнхий сайд болон Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөлд танилцуулсан. Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөлийн зөвлөмжөөр төрийн албаны цалин хөлс, нийгмийн баталгааны нэгдсэн тогтолцоог бий болгох арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Үүний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/126 дугаар тушаалаар Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгээс төрийн албан хаагчийн цалин хөлс, мөнгөн тэтгэмж, нөхөх төлбөр, тусламж олгох харилцааг нэг хуулиар, нийтлэг байдлаар зохицуулах</p>		
--	--	--	--	--	---	--	--

						“Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай” хуулийн төслийг шинээр боловсруулан Улсын Их Хурлын хаврын чуулганд танилцуулахаар ажиллаж байна. Уг хууль батлагдсанаар төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж болон нийгмийн баталгаатай холбогдсон асуудлыг төрөөс бодлогын нэгдсэн зохицуулалтаар хангах боломж бүрдэхийн зэрэгцээ төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хэрэгжилтийг сайжруулахад онцгой ач холбогдолтой. Мөн Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг баталсан.			
5	2.5.5. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	1	Төрийн албан хагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2022-2024	Цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн байна.	Цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн байна.	Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дунджаар 26-60 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Энэ хүрээнд төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 590 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт, төрийн нийтлэг үйлчилгээний /ТНУ/ албан хаагчдын цалингийн доод хэмжээ 565 мян.төгрөг байгааг 750.0 мянган төгрөгт, төрийн захиргааны албан хаагчдын цалингийн доод хэмжээ 717.0 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт, төрийн тусгай албан хаагчдын цалингийн доод хэмжээ 717.0 мян.төгрөг байгааг 1.0 сая төгрөгт хүргэсэн. Дээрх арга хэмжээний хүрээнд 2023 онд нийт 991.5 тэрбум төгрөг зарцуулахаар байна. Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцийн түвшинтэй (Инфляцийн түвшин 2023 оны 8 дугаар сарын байдлаар 10 хувьтай байна) уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримтлан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэхээр тооцон Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд		100

						тусгалаа. Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэгдүүлэх бөгөөд уг арга хэмжээнд 532.4 тэрбум төгрөг шаардагдана.		
2	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан шаттайгаар нэмэгдүүлнэ.	2022-2024	Инфляцын түвшинтэй уялдуулан тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн байна.	Инфляцын түвшинтэй уялдуулан тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн байна.	Засгийн газрын 2023 оны 239 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 10 хувиар нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 550.0 мянган төгрөгт, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 440.0 мянган төгрөгт тус тус хүргэхээр баталсан. Дээрх арга хэмжээний хүрээнд нийт 486.0 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэж, 555.0 мянган төгрөг байсан дундаж тэтгэвэр 685.6 мянган төгрөгт хүрч 2016 оны дундаж тэтгэврийн хэмжээтэй харьцуулахад 2.2 дахин нэмэгдсэн. Мөн 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс тэтгэврийн хэмжээг дунджаар 10 хувиар нэмэгдүүлэхээр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг баталсан.		100	
3	Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтооно.	2020-2024	Тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоож, тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэн, тэтгэврийн зөрүү ойртсон байна.	-	Тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэх ажлын хүрээнд дундаж цалин болон хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтөд үндэслэн 2022 он суурьтай тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийн хувилбарыг боловсруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар тогтоолоор баталсан. Нийгмийн даатгалын ерөнхий газарт 2023 оны 07 дугаар сарын 06-ны		100	

					өдрийн 07/1826 тоот албан бичиг хүргүүлж, хэрэгжилтийг зохицуулан ажилласан. Энэ арга хэмжээний хүрээнд нийт 485.0 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэж, дундаж тэтгэвэр 683.2 мянган төгрөгт хүрсэн.		
4	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг бүсүүдийн хүн амын амьжиргааны түвшний дундажтай тэнцүү болгож нэмэгдүүлнэ.	2022-2024	Тухайн үеийн хүн амын амьжиргааны түвшний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ.	Тухайн үеийн хүн амын амьжиргааны түвшний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ.	Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн 288 мянган төгрөгөөр олгохоор “Тогтоолд өөрчлөлд оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2023 оны 3 дугаар тогтоолоор батлуулав. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 288 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 70 мянга гаруй зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн баталгааг хангах боломж бүрдсэн. Нэмж шаардагдах 109.5 тэрбум хөрөнгийг 2023 оны халамжийн сангийн төсөвт тусгасан. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхээр 2023 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаар 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн батлуулсан. Мөн Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг дараах байдлаар шинэчлэн тогтоов. Үүнд: •Нийгмийн халамжийн тэтгэвэр 288 мянгаас 325 мянган төгрөг, •Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 288 мянгаас 325 мянган төгрөг, •Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэний тэтгэмж 84.5 мянгаас 275 мянган төгрөг, •Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэний тэтгэмж 123.1 мянгаас 275 мянган төгрөг		100

					<p>Нэмэгдэлийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 12.3%, 2020 оноос хойш нэмэгдээгүй байсан асаргааны тэтгэмжийн хэмжээ 2.2-3.2 дахин нэмэгдэв. 2023 онд Хүн амын амьжиргааны түвшин бүсүүдийн дундаж 282,880 төгрөг байгаа ба тэтгэврийн хэмжээ 7 сараас нэмэгдсэнээр АДТ-ээс 12.9 хувиар илүү болсон.</p> <p>Мөн 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс тэтгэврийн хэмжээг дунджаар 10 хувиар нэмэгдүүлэхээр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг баталсан.</p>		
5	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчилж, бага орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	2022-2024	ХХДХ-г инфляцын дундаж түвшин, дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэн тогтооно.	-	<p>Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5.4-т хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос хоёр жилд 1 удаа тогтоохоор заасан байдаг. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 5 дугаар сарын 4-ны 10 дугаар тогтоолоор ХХДХ-г 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 3273 төгрөг 80 мөнгө буюу сард 550000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ийнхүү нэмэгдүүлснээр бага цалинтай хэсгийн орлого 2023 онд 31 хувиар нэмэгдсэн.</p> <p>Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 онд шинэчлэн тогтоох асуудлаар тооцоолол хийж, санал боловсруулах ажлын хэсэг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 4 сарын 20-ны 06 дугаар тогтоолоор байгуулагдсан. Ажлын хэсэг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд заасан харгалзах хүчин зүйлсээр тооцоо, судалгаа хийсэн.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны 12 дугаар тогтоолоор ХХДХ-г 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс</p>	100	

						эхлэн нэг цагт 3929 төгрөг буюу сард 660000 төгрөг байхаар шинэчлэн тогтоогоод байна.		
6	2.5.6.“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.	1	Нийгмийн халамжийн арга хэмжээг нээлттэй, ил тод, олон нийтийн хяналттай, үр дүнтэй, хүнд сурталгүй, албан тушаалтнуудын оролцоогүй болгох зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх	2020-2024	Нийгмийн халамжийн үйлчилгээний 60 хувийг цахимжуулсан байна.	Нийгмийн халамжийн үйлчилгээний 80 хувийг цахимжуулсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолыг үндэслэн хэрэгжүүлж байгаа “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж Халамжийн нэгдсэн систем буюу ehalamj.mn цахим системийг хөгжүүлж байна. 2023 онд Нийгмийн халамжийн 68 төрлийн үйлчилгээг 100 хувь цахим хэлбэрт шилжүүллээ. Ингэснээр иргэд e-mongolia https://e-mongolia.mn/services/citizen/sector/all , ehalamj.mn https://www.ehalamj.mn/ цахим хуудас, төрийн үйлчилгээний цахим машин “ТҮЦ” машин, ebarimt https://ebarimt.mn/ аппликэйшнийг ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргаж, үйлчилгээг бүрэн авах боломжтой боллоо. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах ажилд тусгайлан зардал гараагүй болно.	90
		2	Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим хэлбэрээр хүргэнэ.	2020-2024	Нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулсан байна.	Нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулсан байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, И-Монгол академи хамтран “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт”-ыг e-Mongolia 3.0 системд 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр холбосон. 103 мянган иргэн энэхүү үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн. Нийгмийн даатгалын 34 төрлийн үйлчилгээний 24 үйлчилгээг нь цахимжуулсан. E-Mongolia цахим системд 16 үйлчилгээг холбосон e-Mongolia цахим системээс 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сар хүртэл 7.2 сая удаа нийгмийн даатгалын цахим үйлчилгээг авсан байна. Тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулж, иргэд, тэтгэвэр авагчдын тэтгэврийг	100

					цахимаар тогтоох, цахим хяналт, шалгалтыг сайжруулах, сумын төвөөс аймгийн төв рүү тэтгэврийн хувийн хэргийг шилжүүлэхгүй, зөөвөрлөх шаардлагагүй, нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүргэхээр баруун 8 аймгийн тэтгэврийн хувийн хэргийг 2022 оноос цахимжуулж эхэлсэн. 2023 оны 12 дугаар сарын байдлаар Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Ховд, Хөвсгөл, Увс аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нийтдээ 115,874 тэтгэврийн хувийн хэргээс 95 697 хувийн хэргийг цахимжуулж, цахимжилт 82.6 хувьтай байна. Үүнээс Увс, Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хувьд бүрэн цахимжуулж дууссан.		
3	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэн цахимжуулж, e-job платформыг нэвтрүүлэх	2020-2024	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөр төслийн үйл ажиллагааг нэгтгэсэн байна.	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг ашиглан үйл ажиллагааны төсвийн төлөвлөлт хийж, санхүүжилт олгодог болсон байна.	Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх зорилгоор Хиймэл оюун ухаанд суурилсан Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 оны 12 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлж ашиглалтад оруулсан. “Ejob” платформ нь Онлайн портал, мобайл аппликэйшн, хөдөлмөрийн ажилтнуудын ажиллах хэсэг /back office/ гэсэн 3 дэд систем 13 модулиас бүрдэнэ. Системийн хүрээнд хэрэглэгч өөрийн анкет буюу CV-г байгууллагуудад илгээх, амьдарч буй байршлаас хамааран 1-10 км радиусын хүрээнд ажил хайх, байршлаас үл хамааран ажлын байртай болох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах боломжуудыг бүрдүүлсэн. Тухайлбал, гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэн монголд байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай системээр дамжуулан холбогдож, гэрээт ажил, үүрэг гүйцэтгэх, мөн эх орондоо эргэж ирээд ажиллах боломжийг бүрдүүлсэн.		50

					<p>2023 оны 12 дугаар сарын байдлаар “Ejob” платформд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Бүртгэлтэй ажлын байрны тоо – 70293, 2. Ажил хайгчийн тоо – 87466, 3. Ажил олгогчийн тоо – 12063, 4. Ажилд зуучлагдсан иргэдийн тоо – 19962, 5. Мобайл аппликэйшн хэрэглэгчийн тоо - 29065 болсон байна. <p>Системийн нэвтрүүлэлттэй холбоотойгоор иргэд олон нийтэд таниулах ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээллийн цагаар нийт 64 албан хаагчдад, “Хүртээмжтэй хөдөлмөрийн өдөрлөг”, “Ажил олгогч байгууллагууд, хүний нөөцийн захирлуудтай хийсэн өглөөний уулзалт”, “Career expo-Залуучуудын өдөрлөг”, “Төрийн бус байгууллагуудын холбоо” зэрэг томоохон арга хэмжээ уулзалтад Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформын танилцуулга мэдээллийг хийж, 25113 ажил хайгч иргэн болон 2405 ажил олгогч байгууллага руу танилцуулга, мобайл аппликэйшны холбоосыг масс мессежээр илгээсэн.</p> <p>“Ejob” платформын баталгаат 18 сарын хугацаанд системийг сайжруулахад ХНХЯ, ХХҮЕГ болон гүйцэтгэгч байгууллага болох АйТиЗон ХХК-д мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилго бүхий мэдээллийн технологийн ахлах зөвлөх сонгон шалгаруулан ажиллаж байна.</p> <p>Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/176 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа болон бусад арга хэмжээг цахимжуулах талаар санал боловсруулж танилцуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн 6 удаагийн</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>хурлаар нэгдсэн санал, дүгнэлт гаргаж холбогдох газар, хэлтэст чиглэл өгч биелэлтийг хангуулан үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад танилцуулсан. Түүнчлэн цагийн ажил зуучлалын үйлчилгээг цахимжуулах хүрээнд "Ejob" платформоор дамжуулах, төрийн байгууллагаас гаргасан хөдөлмөрийн цахим үйлчилгээг сурталчилж, гол функц болгон хөгжүүлэлтийг яаралтай хийж сайжруулахаар томоохон аж ахуйн нэгж байгууллага болон холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулан ажлын хэсгийг байгуулан санал боловсруулахаар ажиллаж байна.</p> <p>Тус системээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг ухаалгаар тайлагнах системийг хөгжүүлсэн бөгөөд тайлангийн нийт 36 загвар маягтын хөгжүүлэлтийг хийхээс 20 арга хэмжээний хөгжүүлэлтийг систем хөгжүүлэгч байгууллага хийж хүлээлгэж өгсөн ба үлдсэн 16 арга хэмжээг ондоо багтаан дуусгаж ашиглалтад оруулахаар бэлтгэл ханган ажиллаж байна. Ингэснээр санхүүжилтийг төсөвлөх, санхүүжүүлэх боломжийг бүрдүүллээ. Мөн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг гүйцэтгэсэн хувийн биржийн санхүүжилт эх үүсвэрийг тус системд тайлагнасан байдлаар олгож байна.</p>		
4	Хүн амын бүлэг, эдийн засгийн салбарын хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний "Үйлчлүүлэгч төвтэй аргачлал"-ыг	2020-2024	Хөдөлмөр зуучлалын цахим программ хангамжийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн үйл	Хөдөлмөр зуучлалын мэдээллийн санд ажилтан, ажил олгогчдын мэдээллийг шинэчлэн хамрах хүрээг өргөжүүлсэн байна.	Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем /ejob/ шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан 2023 онд Мэдээллийн технологийн төв, Европын холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй "Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн Зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслийн нэгжтэй, Ай Ти Зон ХХК-тай хамтран Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх мэдээллээр хангах	90	

	<p>нэвтрүүлж, цахимжуулна.</p>		<p>ажиллагаатай холбосон байна.</p>	<p>үйлчилгээ, Хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээ хийх үйлчилгээг үзүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын албан хаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хяналт тавих талаар үе шаттай цахим болон танхимын сургалтыг 6 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 600 гаруй мэргэжилтнүүдийг хамруулсан.</p> <p>Үйлчлүүлэгч төвтэй аргачлалыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлж эхэлсэнтэй холбогдуулан ажилгүй болон ажил хайгч, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай иргэнийг хувь хүний хэрэгцээнд үндэслэн профайлинг буюу хөдөлмөр эрхлэх чадварыг үнэлэх зорилт тавин улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Дээрх үйлчилгээг хэрэгжүүлэхээр 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага 12 дугаар сарын байдлаар 20,074 иргэнд үнэлгээ хийж, хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх төлөвлөгөө гарган төлөвлөгөөг нь хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформын нэг дэд систем нь ажил зуучлалын систем юм. Тус системээр дамжуулан 2023 оны 12 дугаар сарын байдлаар дундын зуучгүйгээр 12000 ажил олгогчийн мэдээллийг шинэчлэн бүртгэлжүүлж 70293 ажлын байранд 19962 иргэнийг ажилд зуучлан хамрах хүрээг нэмэгдүүллээ. Мөн Мобайл аппликэйшн хэрэглэгчийн тоо 29065 болж нэмэгдлээ. Түүнчлэн тус системийг хувийн биржүүд ажил зуучлахдаа ашиглаж байгаа болно. Мөн 21 аймаг 9 дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтсээр дамжуулан 26.2 мянган иргэнийг ажилд</p>		
--	--------------------------------	--	-------------------------------------	---	--	--

					зуучилж холбогдох цахим системд бүртгэл үүсгэсэн.		
5	Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйлчилгээг ил тод, нээлттэй болгон цахимжуулна	2020-2024	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний удирдлага, зохицуулалтыг шинэчлэн үйл ажиллагааг цахимжуулсан байна.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний удирдлага, зохицуулалтыг шинэчлэн, гадаадаас авах ажиллах хүчний тоог тогтоох аргачлалыг мөрдүүлнэ.	Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний зөвшөөрөл олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2020 онд эхлүүлж, цахим системийн хөгжүүлэлт хийгдэн, ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор ezuvsuurul.mn цахим хаягт төвлөрүүлэн бүрэн ашиглалтад оруулан ажиллаж байна. Цахим шилжилттэй холбогдуулан шаардагдах дүрэм журмыг батлуулж, иргэд, аж ахуйн нэгжээс цахим системээр дамжуулан бичиг баримтыг хүлээн авч шийдвэрлэж байна. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль 2022 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан цахим системд нэмэлт хөгжүүлэлтийг ezushuurul.mn-д тусгаж оруулсан. Тус системээр дамжуулан 2023 онд ЗГ-ын 359 дүгээр тогтоолоор 20351 гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгохоор батлагдсанаас 2023 оны 12 дугаар сарын байдлаар 13163 гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгож, 12916 сунгалт хийсэн байна. Мөн Монгол Улсад 2024 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээний саналыг боловсруулахдаа өмнө хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авч ажиллаж байсан гадаад ажилтны тоо мэдээ, аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн холбоодын хүсэлт зэрэгт тулгуурлан тренд тэгшитгэлээр өсөлтийн коэффициентийг тогтоож, шаталсан дундаж, экстерполяцийн аргачлалаар тооцсон бөгөөд Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 319, А/160 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” тус бүрээр гаргасан ба гадаад ажилтны тоог 2024 онд		90

						27851 байхаар Засгийн газрын 2023 оны 360 дугаар тогтоолоор баталсан.			
7	2.5.7.Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна.	1	Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ	2020-2024	Хуулийн төслийг батлуулсан байна.	Хууль тогтоомжийн шинэчлэлтэй уялдуулсан журам, зохицуулалт, аргачлалууд батлагдсан байна.	Нийгмийн халамжийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох яамдаас саналыг авч нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 1/2831 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2022 оны 8 дугаар сард Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотой Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ЗГХЭГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн ХЭГ/1996 дугаар албан бичгээр буцаан ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан яам, агентлагийн ажлын хэсэг 2023 оны 3-4 дүгээр сард Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дахин сайжруулах, холбогдох баримт бичгийн тоо мэдээллийг шинэчилж Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцоог дахин боловсруулж ажиллав. Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл болон Хүүхэд, гэр бүлд тэтгэмж, хөнгөлөлт үзүүлэх, олон хүүхэдтэй эхийг шагнаж, урамшуулах тухай хуулийн төслийг, тандан судалгаанууд, үзэл баримтлалуудын хамт эцэслэн боловсруулсан. ХХҮГ, 21 аймаг, 9 дүүргийн сангийн болон олголтын мэргэжилтнүүд, Багануур дүүрэг болон Хэнтий аймгийн ХХҮГ-ын ажилтнуудад хуулийн төслийг танилцуулан хэлэлцүүлэг хийж, холбогдох хүмүүсийн саналыг хуулийн төсөлд тусган сайжруулах ажлыг хийж байна. Мөн нийслэлийн дүүргүүдийн ХХҮХ, ШШГЕГ, СЭМҮТ, холбогдох төрийн бус байгууллагуудад хуулийн төслийг хэлэлцүүлэх ажлыг хийж байна. Үүний		50

						<p>дараагаар яамны холбогдох газруудад хуулийн төслийг танилцуулах ажлыг хийх юм.</p> <p>Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, тандан судалгааг яамны холбогдох газруудад танилцуулж санал авч, сайдад танилцуулсан. Үзэл баримтлалын төслийг ХЗДХ-ийн сайд, Сангийн сайдтай хамтран батлуулахаар ажиллаж байна.</p>		
	2	<p>Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэх зорилгоор өрхийн амьжиргааны түвшинг төрийн байгууллагын мэдээллийн санд үндэслэн тодорхойлдог байхаар аргачлалыг шинэчлэн, нэвтрүүлнэ.</p>	2020-2024	<p>Шинэчлэгдсэн аргачлалын дагуу зорилтот бүлгийг тодорхойлж, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан байна.</p>	<p>Шинэчлэгдсэн аргачлалын дагуу зорилтот бүлгийг тодорхойлж, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан байна.</p>	<p>Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн хамтарсан А/84, А/89 тоот тушаалаар Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэн баталсан. Засгийн газраас төрийн байгууллагуудын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрд цугларсан их өгөгдлийг төрийн бодлого шийдвэрт ашиглах, төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох эрх зүйн орчин бүрдэж эхэлсэнтэй холбоотойгоор өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Ингэхдээ төрд байгаа мэдээлэлд суурилан өрхийн орлогыг орлуулан тооцох боломжтой, өрхийн амьжиргаанд нөлөө үзүүлэхүйц мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлэх боломжийг бүрдүүлэхээр зорьсон.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 71 дүгээр тогтоолоор хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан нийт хүүхдийн 91 хувьд олгохтой холбоотой "Орлогыг орлуулан тооцох аргаа өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал", "Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал"-ыг тус тус боловсруулж Үндэсний</p>		70

					<p>статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/14, А/04 дүгээр хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан. Энэхүү аргачлалыг шинэчлэн батлахдаа 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллийг үндсэн мэдээлэл болгож ашигласан бөгөөд үүн дээр нэмж төрийн мэдээллийн санд бэлэн байгаа, хууль, эрх зүйн орчны хүрээнд ашиглах боломжтой өрх, иргэний мэдээллийг регистрийн дугаараар холбон холимог мэдээллийн сан үүсгэсэн.</p> <p>-Уг аргачлалын дагуу хүүхдийн мөнгийг 91 хувьд олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p> <p>-Мөн түүнчлэн уг аргачлалын дагуу хүнсний эрхийн бичигт хамрагддаг 26.9 мянган өрхөөс судалгаа авах ажлыг 2023 оны 5 дугаар сард зохион байгуулж ажилласан. Энэ хүрээнд: Орлогыг орлуулан тооцох аргачлал /ООТА/-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/36 дугаар тушаалыг батлуулсан. Уг тушаалын дагуу судалгааг АХБ-ны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-ийн батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулахаар ажлын удирдамж, төсвийн тооцооллыг бэлтгэж, АХБ болон Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлсэн. ООТА-аар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 26,900 өрхийг хамруулан улсын хэмжээнд 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр эхлүүлсэн. Зөвөрийн төхөөрөмжид зориулсан судалгааны программыг үндсэн системийн</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>хамт ашиглалтад оруулж, 21 аймаг, 9 дүүргийн ХХҮГ/ХХҮХ-ийн дарга, мэргэжилтэн болон судалгааны багийн гишүүдэд программ хангамжийн сургалтуудыг танхим болон цахимаар зохион байгуулав. Мэдээлэл технологийн ажилтнуудад rmt2022 систем болон түүний хэрэглэгчийн болоод судалгааны модулийн ашиглалтын сургалтыг 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар 5 удаа зохион байгуулсан. Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд 26,900 өрхийн жагсаалтыг бэлтгэсэн. Өрхийн жагсаалтад орсон өрхүүдийг тоологчид хуваарилах болон газрын зурагт тэмдэглэх ажлуудыг хийлгэсэн.</p> <p>Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтан болон багийн ахлагч/сургагч багшийн сургалтын бэлтгэлийг хангаж, сургалтыг 5 дугаар сарын 11-13-ны өдөр 70 хүнийг хамруулан, Улаанбаатар хотод танхимаар, тоологчийн сургалтыг аймаг, дүүргийн ХХҮГ/ХХҮХ нь аймаг, дүүргийн хэмжээнд 5 дугаар сарын 21-23-ны өдөр 700 орчим тоологч, ахлагчийг хамруулж танхимаар (хувь зөвлөх цахимаар зөвлөж, чиглүүлж, зарим бүсэд дахин сургалт хийсэн) зохион байгуулсан.</p> <p>Судалгааны урьдчилсан дүнгээр нийт хамрагдах өрхийн 99.1% хамрагдсан бөгөөд 2023 онд багтаан эрүүл мэндийн даатгал, татвар зэрэг төрийн бусад байгууллагаас шаардлагатай мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлэх ажил хийж дуусгах юм. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлээр халамжийг хэрэгцээ, шаардлагатай хэсэгт чиглүүлэх, амьжиргааны түвшин, өрхийн эмзэг байдалтай уялдуулах тул энэ аргачлалын дагуу бүрдсэн мэдээллийн сангийн ашиглалт нэмэгдэх бөгөөд цаашид төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох замаар Монгол Улсын бүх өрхийн амьжиргааг</p>	
--	--	--	--	--	---	--

					үнэлэх, өрхийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх шаардлагатай байгаа юм.			
	3	Цалинтай ээж” хөтөлбөрийг үргэлжлүүлж, 3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд ялгаварлалгүй олгоно.	2020-2024	-	-	Улсын Их Хурлаас 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг баталж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна. Дээрх хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журмыг баталсан. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмжид нийт 181,030 иргэн хамрагдаж 71,6 тэрбум төгрөг зарцуулсан байна.		100
	4	Ахмад настны амьжиргааг дэмжиж, орлогын баталгааг хангах зорилгоор "Насны хишиг" тэтгэмжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2020-2024	65 ба түүнээс дээш насны бүх ахмад настан бүрэн хамрагдсан байна.	65 ба түүнээс дээш насны бүх ахмад настан бүрэн хамрагдсан байна.	Ахмад настны тухай хуульд заасны дагуу Насны хишиг тэтгэмжийг 2017 оноос эхлэн жилд 2 удаа 65 ба түүнээс дээш настай ахмадуудад олгосон. Насны хишиг тэтгэмж нь ахмад настануудын эрүүл насжих, тэдний орлогын баталгааг бууруулахгүй байхад чиглэсэн томоохон дэмжлэг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 65 ба түүнээс дээш настай 176,906 ахмад настанд 26,6 тэрбум төгрөгийн насны хишиг тэтгэмжийг олгоод байна.		100

8	2.5.8. Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.	1	Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг батлуулан гэр бүлийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчинг бий болгох, шинэ төрлийн үйлчилгээг бий болгож нэвтрүүлнэ.	2021-2024	Хуулийн хэрэгжилтийг хангаж, дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулсан байна.	Гэр бүлийн хөгжлийг дэмжих шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	<ul style="list-style-type: none"> - Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг 2023.11.01-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр УИХ-д өргөн барьсан. - Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн олонх буюу 85.7 хувь нь дэмжиж, нэгдсэн хуралдаанд танилцуулахаар шийдвэрлэсэн. - УИХ-ын чуулганы 11 дүгээр сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн 58 хувь нь дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн. - Гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээний стандартын төслийг боловсруулж, батлуулахаар Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсний дагуу албан ёсоор хүргүүлсэн. 	70
		2	Хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжих асуудлаарх эрх зүйн орчныг шинэчилж, шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	2021-2024	Хуулиудын хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох дүрэм журмыг батлуулсан байна.	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангаж	1/ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг баталсан үзэл баримтлалын дагуу Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцтэй нийцүүлэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг, 59 зүйлтэй боловсруулсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн	70

				ажилласан байна.	<p>хуралдаанаар хэлэлцэж, хэлэлцэхийг Улсын Их Хурлаас дэмжсэн болно. Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>2/ Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, “Хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 378 дугаар тогтоол 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн батлагдсантай холбогдуулан тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт “Хамтран ажиллах тухай” 01/2828 тоот албан бичгийг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт “Чиглэл хүргүүлэх тухай” 01/2827 тоот албан бичгийг тус тус 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хүргүүлсэн. Албан бичгүүдэд Аймгийн Засаг даргын Тамгын газар нь тус тогтоолын 3 дугаарт заасны дагуу “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”-ыг “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар” болгон өөрчлөн зохион байгуулж, тус тогтоолын 1 дүгээрт заасны дагуу Залуучуудын хөгжлийн төвийн чиг үүргийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд хамааруулах, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тус тогтоолын 6 дугаарт заасны дагуу “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”-ыг “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар” болгон өөрчлөн зохион байгуулах, тус тогтоолын 2 дугаарт заасны дагуу Залуучуудын хөгжлийн газрыг Залуучуудын хөгжлийн төвтэйгээр ажиллуулах; Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь тогтоолын 4 дүгээрт дурдсаны дагуу “Хүүхэд, гэр бүлийн хөгжил,</p>		
--	--	--	--	------------------	---	--	--

					<p>хамгааллын ерөнхий газар" гэж өөрчлөх бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг хурдан шуурхай зохион байгуулахыг чиглэл болгосон.</p> <p>3/ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг хамтад нь батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл, хуулийн тандан судалгаа, үр нөлөөний судалгаа, зардлын тооцоог боловсруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг дагалдан 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан.</p> <p>Хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 10 удаа хэлэлцүүлсэн бөгөөд ирсэн саналыг тусган ажилласан.</p> <p>Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулахаар үзэл баримтлалын төсөл, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн тайлан, үзэл баримтлалын төслийн танилцуулгын хамт 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 01/3015 тоот бичгээр хүргүүлсэн.</p> <p>Мөн хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх зөвшөөрөл авах албан тоот хүргүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.</p> <p>Хуулийн III бүлэг буюу хүртээмжтэй орчин нөхцөлийн 8-12 дугаар зүйл нь Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөлд орж байгаа бөгөөд үндсэн асуудлаар шинээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сантай холбоотой 1 бүлэг, хүний нөөц бэлтгэх, төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, салбарын нийгмийн хамгааллын асуудлаар 3 зүйл нэмэгдэж, хуулийн 70-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байна.</p>		
--	--	--	--	--	--	--	--

3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд саадгүй оролцох, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2021-2024	Хуулийн хүрээнд холбогдох дүрэм журмыг боловсруулан батлуулсан байна.	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	<p>Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулсан бөгөөд 6 бүлэг, 23 зүйлээс бүрдэх юм. Хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 10 удаа хэлэлцүүлсэн бөгөөд ирсэн саналыг тусган ажилласан.</p> <p>Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулахаар үзэл баримтлалын төсөл, хуулийг хэрэгжүүлэх урьдчилсан тандан судалгаа, үзэл баримтлалын төслийн танилцуулгын хамт 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/3060 тоот бичгээр хүргүүлсэн.</p> <p>Мөн хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх зөвшөөрөл авах албан тоот хүргүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандан судалгааг эцэслэн боловсруулсан. Мөн хуулийг даган гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.</p>		50
4	Хүн амын амьдралын таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн Хүн амын хөгжлийн зорилтот хөтөлбөр, хүүхэд, залуучууд, ахмад настан, удмын сан, гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил,	2021-2024	Хөгжлийн зорилтот хөтөлбөр, арга хэмжээний нэгдүгээр шатны /2022-2024/ хэрэгжилтийн төлөвлөгөөг сайдын тушаалаар баталж, хэрэгжилт 20-с доошгүй хувьд хүрсэн байна.	Хөгжлийн зорилтот хөтөлбөр, арга хэмжээний нэгдүгээр шатны (2022-2024) төлөвлөгөөний хэрэгжилт 60-аас доошгүй хувьд хүрсэн байна.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар Монгол Улс урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй байхаар заасан. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан. Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэхүйц байхаар тодорхойлж хөгжлийн		50

<p>хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>				<p>зорилтот хөтөлбөртэй байхаар хуульчилсан. Дээрх хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах ажлын дэд хэсгүүдийг ЭЗХ-ийн сайдын 2022 оны А/38 дугаар тушаалаар баталж, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр /НХЗХ/ боловсруулах дэд ажлын хэсгийн ахлагчаар С.Зулпхар, нарийн бичгийн даргаар А.Хишигбаяр нар ажиллаж байна.</p> <p>НХЗХ-ийн төслийг СЯ, ХХААХҮЯ, БХБЯ, ЭМЯ, ХЗДХЯ-ны төлөөлөл болон ХНХЯ-ны хүн ам, гэр бүл, хөдөлмөр эрхлэлтийн газрын удирдлага, албан хаагчдад танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулсан. Мөн ЭЗХЯ-наас 2 удаа зохион байгуулсан Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх семинарт тус хөтөлбөрийг боловсруулах ажлын багийн бүрэлдэхүүн оролцон хөтөлбөрийн төслийг бусад хөтөлбөртэй уялдуулах, давхардал, хийдэгдлийг арилгах, хариуцах салбар байгууллага, хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг тодорхойлох чиглэлээр бусад хөтөлбөрийн ажлын хэсэгтэй хамтран ажиллалаа.</p> <p>Хөтөлбөрийн төслийг 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 7 дугаар сарын 5-ны өдөр УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлж, буцаагдсан.</p> <p>Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах дэд ажлын хэсгээс 2023 онд хөтөлбөрийн төслийг олон улсын байгууллагын болон төрийн бус байгууллагын төлөөлөлд танилцуулж санал авах ажлыг зохион байгуулж, оролцогчдын саналыг ЭЗХЯ-д хүргүүлсэн.</p>		
---	--	--	--	--	--	--

		<p>Эрүүл, бүтээлч амьдрал, идэвхтэй, насжилтыг дэмжсэн, ахмад настанд ээлтэй, тэгш хүртээмжтэй урт хугацааны тусламж үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлнэ.</p>	<p>2021-2024</p>	<p>Төлөвлөгөөний хэрэгжилт 30-с доошгүй хувьд хүрсэн байна.</p>	<p>Төлөвлөгөөний хэрэгжилт 50-с доошгүй хувьд хүрсэн байна.</p>	<p>Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загварыг туршин нэвтрүүлэхээр ХНХЯ, ЭМЯ хамтран 3 зорилтын хүрээнд 24 үйл ажиллагаа бүхий “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022 оны А/127, А/333 тоот хамтарсан тушаалаар баталсан. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд: -Аймаг, сум, нийслэлээс Сонгинохайрхан дүүрэгт “Ачлалт хүүхдүүд” ТББ, Дархан-Уул аймагт “Ахмадын хөгжлийн төв”, Сэлэнгэ аймгийн Мандал суманд Нэгдсэн эмнэлгийг түшиглэн 3 байршлыг сонгон хэрэгжүүлж байна. -Сонгосон 3 байршилд Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаж байна. -Сонгосон байршлын Идэвхитэй насжилтын төвд шаардлагатай нөөц, чадавхийг тодорхойлох үнэлгээ хийв. -Идэвхитэй насжилтыг дэмжих төвийн үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө сонгосон орон нутгийн холбогдох удирдлага, мэргэжилтнүүдтэй долоо хоногийн цахим уулзалтыг тогтмол зохион байгуулж, эхний улирлын байдлаар 7 удаагийн уулзалт зохион байгуулав. -Ахмад настны кейс менежментийн 5 өдрийн сургалт, хүний нөөцийг чадавхижуулах сургалтыг тус тус зохион байгуулав. -Төслийн удирдах хорооны гишүүд болон Сонгинохайрхан дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудтай хамтарч ахмадуудад чиглэсэн үйлчилгээ, дэмжлэг, хөрөнгө, нөөц боломж, давуу талуудыг илрүүлэх, тодорхойлох, тэдгээрийг “Идэвхтэй насжилтыг дэмжих төв”-ийн үйл ажиллагаатай уялдуулах зорилгоор уулзалтыг зохион байгуулав.</p>		<p>100</p>
--	--	--	------------------	---	---	--	--	------------

					<p>-Төслийн хүрээнд “Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн мэдээлэл, лавлагаа, холбон зуучлах үйлчилгээ болон кейс менежментийн үйлчилгээний заавар боловсруулах” сургалтыг 2023 оны 5 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт зохион байгууллаа.</p> <p>Тус сургалтыг Азийн хөгжлийн банкны Олон Улсын зөвлөхүүд, дотоодын зөвлөхүүд болон Геронтологийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан.</p> <p>Сургалтаар мэдээлэл, лавлагаа холбон зуучлах үйлчилгээ гэж юу вэ?, харилцаа холбоо тогтоох чадвар, олон нийтийн нөөц тодорхойлолт, удирдлага хөгжил, байгууллагын мэдээлэл лавлагаа холбон зуучлах үйлчилгээний дотоод хамтын ажиллагаа, холбон зуучлах үйлчилгээний ерөнхий зураглал, үр дүнтэй мэдээлэл, лавлагаа, холбон зуучлах үйлчилгээний шалгуур үзүүлэлтүүд сэдвүүдээр мэдлэг олгов. Мөн Кейс менежментийн үйл ажиллагааны удирдамжийг дараах сэдвүүдийн дагуу боловсруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Суурь үйлчилгээ (хоол, хувцас), мэдээллээр хангах • Сэргээн засах үйлчилгээ • Өдрийн үйлчилгээ • Нийгмийн оролцоог дэмжих, боловсрол, хөгжлийн үйлчилгээ • Асаргаа үзүүлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ • Гэрээр явуулын тусламж үйлчилгээ • Түр хугацаагаар байрлуулан асрах үйлчилгээ • Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ • Кейс менежментийн үйлчилгээ <p>Энэхүү сургалт нь Монгол орны нөхцөлд Кейс менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны удирдамжийг</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>боловсруулан, бодлогын баримт бичигт тусгуулах ажлын эхлэлийг тавьснаараа ач холбогдолтой сургалт боллоо.</p> <p>АХБ-тай хамтран “Урт хугацааны тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоо” сургалтыг дараах үе шаттай зохион байгуулав.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Урт хугацааны тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоо эхний шатны сургалтыг 2023.07.04-06 ний өдрүүдэд удирдах шатны албан хаагчид, • Урт хугацааны тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоо дараагийн шатны сургалтыг 2023.08.22-нд зохион байгуулж, Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Геронтологийн үндэсний төв, АХБ-ны төлөөлөл зэрэг 30 гаруй төлөөлөл оролцон, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, салбар дундын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн цогц тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хэлэлцүүлэв. <p>АХБ-ны ТА9928 төслийн баг Монгол Улсад 2023 оны 10 дугаар сарын 10-14-нд ажиллаж, төслийн оролцогч талуудтай төслийн хэрэгжилтийн талаар санал солилцох уулзалт хийж, Идэвхитэй насжилтын төвийн үйл ажиллагаатай танилцан, зөвлөмж, чиглэл өгч ажиллав. Мөн 10 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Идэвхитэй насжилтын төвийн албан хаагчдад явуулын тусламж үйлчилгээ үзүүлэх, тус үйлчилгээг боловсронгуй болгох нь сургалтыг зохион байгуулж, нийт 40 албан хаагчийг хамруулав.</p>	
6	Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлнэ.	2021-2024	Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн 70 хувьд урьдчилан сэргийлэх	Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн 80 хувьд урьдчилан сэргийлэх	<ul style="list-style-type: none"> • Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн мэдээллийг хүлээн авч, шуурхай тусламж үйлчилгээ, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлж байна. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 2023 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 	90

			<p>үйлчилгээ, хамгаалал шаардлагатай хүүхдэд хариу үйлчилгээг 100 хувь үзүүлсэн байна.</p>	<p>үйлчилгээ, хамгаалал шаардлагатай хүүхдэд хариу үйлчилгээг 100 хувь үзүүлсэн байна.</p>	<p>нийт 96128 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэн. Үүнээс зорилтот 54173, зорилтот бус 41955 дуудлага, мэдээлэл байна.</p> <ul style="list-style-type: none"> • Нийт зорилтот 54173 дуудлага, мэдээллээс хүүхэд хамгааллын 13318, зөвлөгөө хүссэн 6033, мэдээлэл хүссэн 34749 дуудлага мэдээлэл тус тус байна. • Мөн хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай 9449 дуудлага, мэдээллийг 21 аймаг, нийслэл 9 дүүргийн Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын газар, хэлтсүүдэд шилжүүлснээс 6748-ийг шийдвэрлэж хаасан, 2701 дуудлага, мэдээлэл дээр хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Нийт Зорилтот 54173 дуудлага, мэдээллээс хүүхэд хамгааллын 13318, зөвлөгөө хүссэн 6033, мэдээлэл хүссэн 34749 дуудлага мэдээлэл тус тус байна. • Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд заасан Хүүхдийн эрхийн зөрчлийн хүрээнд нийт 103 гомдол мэдээллийг хүлээн авч, 67 зөрчил шалган шийдвэрлэсэн бөгөөд нийт 29,4 сая төгрөгийн мөнгөн торгууль оногдуулсан. Шийдвэрлэлт 82.5 хувьтай байна. Хүүхдийн эрхийн улсын байцаагчдыг бэлтгэх сургалтыг зохион байгуулж, хуулийн шаардлага хангаж шалгалтад тэнцсэн 14 албан хаагчид Улсын байцаагчийн эрх олгохоор хянаж байна. • Хүүхдийн эрхийн хууль зүйн Хорооны ажлын албыг чадавхжуулах ментор хөтөлбөр 11 аймаг, 4 дүүрэгт хэрэгжиж, хөтөлбөрийн хүрээнд ажлын албаны гишүүдийг чадавхжуулах сургалт 1 удаа, 11 аймаг, 4 дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн Хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт 1 удаа, аймаг, дүүргийн Хууль зүйн хороо, Ажлын албыг ажлын байран дээр чадавхжуулах, зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулагдаж, энэ хүрээнд 52 кейс 	
--	--	--	--	--	---	--

					<p>дээр ажиллаж үр дүнтэй шийдвэрлэсэн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар 1226 хүүхдэд хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлсэн нь хүүхдийн кейс шийдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс 10 хувиар өссөн байна. /хагас, бүтэн жилээр тайлан гардаг/</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, Хөдөлмөрийн тухай хууль холбогдох жагсаалтуудыг мөрдүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг тогтмол зохион байгуулж байна. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар хөдөлмөр эрхэлж байгаа 324 хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. <p>Үндэсний их баяр наадмын тухай хууль болон “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018 стандарт”-ын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулж, уралдааны зам талбайн халтиргаа гулгаа, эвдрэл гэмтэл, аюулгүй байдалд хяналт тавьж, хурдан морины уралдаан дагах автомашины хязгаарыг тогтоож, тоог цөөлөх, шүдэлгээ, хэмжилтээс хасагдсан морины хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж, хүүхдийн хувцас хэрэгсэлд холбогдох стандартын хяналтыг тавьж, зөрчлийг арилгуулах, гарааны зурхай дээр ажиллаж байгаа цагдаагийн байгууллагын ажилтны тоог нэмэх, гараанаас бурсан морийг залах, замд нь оруулах, хувцас хэрэгслийн хяналт тавих явцад морь хөтлөх ажилтны тоог нэмэх зэрэг шаардлага тавьж биелэлтийг хангууллаа. 2023 онд нийт 352 уралдаанд 11032 хүүхэд бүртгүүлж, хурдан морь унаж оролцлоо.</p>		
7	Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц	2021-2024	Гэр бүл, хүүхэд, залуучууд ахмад настны	Гэр бүл, хүүхэд, залуучууд ахмад настны	Гэр бүлд зөвлөгөө өгөх төв болон Залуучуудын хөгжлийн төвөөр дараах үйлчилгээг тус тус авсан. Үүнд:	100	

	төвүүдийг байгуулж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ		хөгжлийн цогц төвийн үйлчилгээг нийт хүн амын 10-с доошгүй хувьд хүргэсэн байна.	хөгжлийн цогц төвийн үйлчилгээг нийт хүн амын 20-с доошгүй хувьд хүргэсэн байна.	<ul style="list-style-type: none"> Гэр бүлийн боловсрол олгох сургалт, гэр бүлд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ, байгууллага, ААН-ийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн гишүүд, эцэг эхчүүдэд чиглэсэн хөгжлийн үйлчилгээ, арга зүйн дэмжлэг явуулын үйлчилгээ үзүүлэх зэрэг урьдчилсан сэргийлэх үйл ажиллагаанд 355.621 /36.6%/ иргэн хамрагдсан байна. <p>Аймаг, дүүрэг, зарим сумдын Залуучуудын хөгжлийн 43 төвөөр нийт 284,627 залуучууд буюу 15-34 насны нийт залуучуудын 28,1 хувь нь хамрагдаж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан залуучуудын хөгжлийг дэмжих 7 төрлийн үйлчилгээ авсан байна. /хагас, бүтэн жилээр тайлан гардаг/</p>	
8	Хүүхдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөгжлийн үйлчилгээг хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.	2021-2024	Найрамдал-2 зуслангийн барилгын ажлын хувийг гүйцэтгэсэн байна. 60	"Найрамдал-2" зуслангийн үйл ажиллагаа эхэлж 26,000 хүүхэд хүүхдийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан байна.	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/26 дугаар тушаалаар Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслан байгуулах бодлого зохицуулалт, бэлтгэл ажлыг ханган ажиллах чиг үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийг байгуулан ажиллаж дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Барилга хот байгуулалтын яамнаас зуслангийн зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж, "Эм Эс Эл" ХХК шалгарч, зураг төслийн ажлыг бүрэн гүйцэтгэсэн. -Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслангийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, стратегийг боловсруулж, зураг төслийн 3D видео танилцуулга хийсэн. -Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. -Тус зусланг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгоны нутаг дэвсгэр болох Хөвсгөл нуурын эрэгт нийт 60 га талбайд байгуулахаар шийдвэрлэж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 0211841 	30

					дугаартай 5 жилээр газар эзэмших гэрчилгээг олгосон. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар “Олон улсын Хүүхдийн Найрамдал-2” төсөл арга хэмжээний Өвлийн байрны барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. Нээлттэй тендер шалгаруулалтыг 3 удаа зарлаж, зохион байгуулсан боловч тендерт нэг ч оролцогч тендер ирүүлээгүй тул тендер амжилтгүй болсон.		
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг нэвтрүүлнэ.	2021-2024	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвүүдийн барилгын ажлыг бүрэн дуусгасан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвүүдэд шинэ үйлчилгээнүүд ийг нэвтрүүлж, үйлчлүүлсэн хүний тоо 2500-д хүрсэн байна.	Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Архангай, Дархан-Уул, Хөвсгөл, Дундговь, Дорнод, Ховд аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулахаар төлөвлөсөн. Үүний дагуу төвийн бүтэц, үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/159 дүгээр тушаалаар баталж, Дархан-Уул, Хөвсгөл, Дундговь, Дорнод, Ховд аймгийн ХБХТ-ийн барилгыг 2022 онд хүлээн авсан. Төвийн үйл ажиллагааг 2023 оны 9 дүгээр сараас эхлэн үзүүлж, 10 дугаар сарын байдлаар 2053 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд үзлэг, сургалт мэдээлэл, эмчилгээ, зөвлөгөөний үйлчилгээ үзүүлсэн байна. Архангай аймагт баригдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга 50%-ийн гүйцэтгэлтэй байна.		100
		2021-2024	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилгын	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд	Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Улаанбаатар хотод байгуулагдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын угсралтын ажлыг 2022 оноос “Би		50

	ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.	хамрагдах боломж, хүртээмж нэмэгдсэн байна	энд Би” ХХК–тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, барилга угсралтын ажил 75 хувийн гүйцэтгэлтэй байна.		
2021-2024	Спорт цогцолборын барилгын ажлыг эхэлсэн байна.	Спорт цогцолборын барилгын ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.	<p>“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолбор” барих ажлыг 2016 оны 6 дугаар сард БНХАУ-ын Худалдааны сайдын Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр хэлэлцэн Монгол Улсын Гадаад хэргийн сайд, БНХАУ-ын Худалдааны сайд нарын түвшинд буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 20.4 сая ам.долларын төсөвт өртөгтэйгээр барихаар шийдвэрлэж үзэглэсэн.</p> <p>Тус ордонг Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо, Чингис хаан олон улсын нисэх буудлын нисэх, буух зурвасын баруун талд 10 га-д барихаар Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/112 дугаар захирамжаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 15 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрхийг олгоод байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолбор нь нийтдээ 19,567.0м2 талбай бүхий зоорьтой 7 давхар барилга бөгөөд зочид буудал, 200м тойрог бүхий манеж, гадна талдаа 400м тартан зам, 200 ортой тамирчдын байрлах байр, 150 хүн зэрэг хооллох хоолны газар, хурлын танхим, заалны тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн явуулах спорт заал, фитнес заал, жудо бөх, хүндийн өргөлт, таеквандо, сагсан бөмбөг, суугаа волейбол, ширээний теннис, хөнгөн атлетик, байт харваа, хонхот бөмбөг, буудлага зэрэг пара спортын 10 төрөлд зэрэг хичээллэх боломжтой бэлтгэлийн заалтай олон улсын стандартад нийцсэн тусгай тоноглол бүхий цогцолбор байна. Спорт цогцолбор нь жилийн 4 улиралд 200-400 тамирчин 10 төрлөөр тогтмол хичээллэх</p>		30

						<p>боломжтой орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан.</p> <p>БНХАУ-ын талаас “Цахим инженерийн зураг төслийн институт ХХК”-ийн судалгааны ажлын хэсэг Монгол Улсад 2019 оны 4-5 дугаар сард Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Барилга, хот байгуулалтын яамны холбогдох удирдлага, ажилтнууд, Монгол Улсын зөвлөх инженерийн баг, Нийслэлийн харьяа 10 гаруй байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан. Судалгааны багийн ажлын үр дүнд зургийн ажлын тендер БНХАУ-д зарлагдан гүйцэтгэгч барилгын зургийг боловсруулж бэлэн болгосон. Монголын талаас хариуцан гүйцэтгэх инженер, геологийн судалгаа хийгдэж, холбогдох техникийн нөхцөлүүд гарсан.</p> <p>“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2.12-д Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан бөгөөд тус жагсаалтын 25 дугаарт төслийн нийт санхүүжилт 54,7 тэрбум (2021 онд 15,0; 2022 онд 25,0; 2023 онд 12,0; 2024 онд 2,7;) төгрөгийн төсвийг гадаадын зээл тусламжийн хүрээнд байгуулахаар тусгасан.</p>		
9	2.5.9.Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад	1	Орлого багатай өрхийн гишүүдэд мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулж,	2020-2024	Хөтөлбөр, төслийг хэрэгжүүлсэн байна.	Хөтөлбөр, төслийг хэрэгжүүлсэн байна.	Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн иргэдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулах замаар хөдөлмөрт бэлтгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төсөл, “Эрэлтэд нийцсэн ур чадвар” хөтөлбөр, “Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад нь дэмжлэг	90

	<p>хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.</p>	<p>ажилд зуучлах, онцлог хэрэгцээнд нийцүүлсэн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлнэ.</p>				<p>үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийг тус тус хэрэгжүүлж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2021 оноос эхлэн 18-34 насны, сүүлийн 3 сар ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа болон хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй өрхийн хөдөлмөрийн насанд хүрсэн 34 хүртэлх насны залуучуудыг хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадварт суралцуулж, ажлын байранд зуучлах зарчмаар хэрэгжүүлж байна. Төсөлд 2021 онд 2328, 2022 онд 1233 залуучуудыг, 2023 онд “Оюутан цэрэг” хөтөлбөртэй хамтран 1500 залуучуудыг хамруулсан. Сургалтын үндсэн агуулга болох хувь хүний хөгжил, манлайлал, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадвар /soft skills/, хөдөлмөрт бэлтгэх чиглэлийн хичээлүүд болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ын агуулгыг зааж 2023 онд 2.0 тэрбум төгрөгийг зарцуулав. “Эрэлтэд нийцсэн ур чадвар”-ын хөтөлбөрийн төслийг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор тус хөтөлбөрийг батлуулсан. Мөн уг хөтөлбөрийн удирдамжийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 27 ны өдрийн А/145 тоот тушаалаар батлуулж бэлтгэл ажлыг ханган, бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. <p>Тус хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, хувь хүний хэрэгцээнд тулгуурлан ажилгүй, ажил хайж байгаа, ажил олоход хүндрэлтэй, мэргэшлийн түвшнээ ахиулах хүсэлтэй иргэнийг</p>		
--	---	---	--	--	--	--	--	--

						<p>хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадвар болон мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах замаар ажилтай, орлоготой болгох, ажлын байраар хангах зорилготойгоор 1200 иргэнийг /700 хүнд мэргэжил олгох, 300 хүнийг мэргэшүүлэх, 200 хүнийг өмнөх мэдлэг ур чадварыг үнэлэх үнэлгээнд хамруулах/ хамруулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.</p> <ul style="list-style-type: none"> • 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд тусгагдсан Ажил олоход хүндрэлтэй иргэнийг урт хугацаанд тогтвортой ажлын байраар хангасан ажил олгогчид цалингийн дэмжлэг үзүүлэх тухай" арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцээд тусгайлсан хөтөлбөр боловсруулан батлуулсан. • Ажил олгогчийг дэмжих туршилтын төслийн журмыг боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар танилцуулж Засгийн газарт танилцуулах зөвлөмжийг гаргасан. • Үүний дагуу энэхүү туршилтын төслийг Засгийн газарт 2023 оны 10 дугаар сарын 11-нд танилцуулснаар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт чиглэл хүргүүлсэн. Уг арга хэмжээний зардлыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тусгаж 5200 хүнийг хамруулахаар ажиллаж байна. 21 аймаг 9 дүүргийн ХХҮГ, хэлтсүүдийн хөдөлмөрийн асуудал 		
--	--	--	--	--	--	--	--	--

						<p>хариуцсан хэлтэс, албадын дарга болон мэргэжилтнүүдтэй энэхүү арга хэмжээний талаар цахимаар сургалт зохион байгуулж ажилласан. Аж ахуйн нэгж байгууллагад цалингийн дэмжлэг олгосноор тухайн байгууллагын санхүү, хүний нөөцийн үйл ажиллагаанд тодорхой хувь нэмэр оруулах, ажил олоход хүндрэлтэй иргэнийг дагалдан ажилтнаар дадлагажуулах замаар байнгын ажлын байраар хангах, шаардлагатай ур чадвар эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх боломж бүрдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Тус яам, “Жайка” олон улсын байгууллагатай хамтран техникийн туслалцааны төсөл болох “Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг 2023-2027 оны хооронд хэрэгжүүлэх ба төслийн үйл ажиллагааг 2023 оны 6 сараас эхлүүлсэн. Энэхүү төслийн хүрээнд “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-т Япон улсын бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг тусган нэвтрүүлж, сайжруулах бодлогын зөвлөмж боловсруулан Монгол Улсын онцлогт тохирсон загвар төслийг бий болгох зорилготой. Тухайлбал, Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийг сайжруулах суурь судалгааг хийж, туршилтын төслийг боловсруулан шаардлагатай хүний нөөцийг бэлдэх, сургалтын аргазүйг тодорхойлох, сургалтын материал боловсруулах, сургалтын байгууллагын сүлжээг бий болгох замаар туршилтын төслийг Баянзүрх дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Дундговь аймагт хэрэгжүүлэхээр сонгосон. Одоогоор туршилтын төслийн суурь судалгаа хийгдэж зураглал, хамрах 	
--	--	--	--	--	--	--	--

						хүрээг тодорхойлоод байна. Энэ хүрээнд зорилтот 1500 өрхийг хамруулан хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.		
	2	Хүн амын бүлгүүд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж, хөдөлмөрт бэлтгэх, аж ахуй эрхлэх болон бусад үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ.	2020-2024	Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийж, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох хөтөлбөр, арга хэмжээ болон төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г баталсан.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-нд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг дэмжих, Засгийн газар болон хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 үйл ажиллагааны 34 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/16 дугаар тоот тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлан хэрэгжүүлж байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд 2023 оны 12 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор 48.1 мянган хүн хамрагдаж 44.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээний хүрээнд 32.6 мянган ажлын байрыг бий болгож, хадгалсанаас 7.9 мянга нь байнгын, 20.2 мянга нь түр, 4.5 мянга нь цагийн ажлын байр байна.</p>		100

						Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамжийн газар, хэлтсийн 160 албан хаагчийг чадавхжуулах сургалтыг Европын холбооны санхүүжилттэй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих” төсөлтэй хамтран зохион байгуулсан. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2021 оноос эхлэн 18-34 насны, сүүлийн 3 сар ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа болон хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй өрхийн хөдөлмөрийн насанд хүрсэн 34 хүртэлх насны залуучуудыг хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай зөөлөн ур чадварт суралцуулж, ажлын байранд зуучлах зарчмаар хэрэгжүүлж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар “Оюутан цэрэг” хөтөлбөртэй хамтран 1500 залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулсан. Цаашид 2500 залуучуудыг хамруулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.			
12	2.5.12.“Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ.	3	Хүүхэд бүрт хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгоно.	2020-2024	-	Хүүхэд бүр “Хүүхэд хөгжлийн карт”-тай болсон байна.	Хүүхдийн мөнгийг 2023 оны 7 дугаар сараас бүх хүүхдэд олгохтой холбоотой Засгийн газрын 2023 оны 236 дугаар тогтоолоор “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-ыг шинэчлэн баталсан. Уг журамд хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих, соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах зэрэг хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор Хүүхдийн төлөө санд хүүхдийн мөнгөө шилжүүлэх зохицуулалт туссан. Мөн хүүхдийн эцэг, эх асран хамгаалагч хүүхдийн мөнгийг согтууруулах ундаа, тамхины хэрэглээнд зарцуулахгүй байх тухай зохицуулалт тусгаж, халамжийн байгууллага болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, хүүхдийн эрхийн байцаагч хяналт тавих,эцэг, эх нь хүүхдээ асран хамгаалах, т		70

						<p>эжээн тэтгэх үүргээ үл биелүүлсэн, хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хүүхдийн мөнгийг түр түдгэлзүүлэх зохицуулалтууд туссан. Монгол Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг 2021 оны 11 сард баталж, Ирээдүйн өв сангийн 2022 оны орлогоос Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд мөнгөн хуримтлал үүсгэх хууль эрх зүйн боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг уул уурхайн баялгийн өгөөжид суурилсан “Хуримтлалтай Монгол хүүхэд” хөтөлбөр хэлбэрээр хэрэгжих боломж бүрдсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор “Хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журам”-ыг баталсан. Уг журмын дагуу Монгол Улсын иргэн 18 нас хүрснээр Хүүхдийн мөнгөн хуримтлалыг мөнгөн хэлбэрээр авах бөгөөд энэ хүртэлх хугацаанд хуримтлалыг Төрийн сан дахь “Хүүхдийн мөнгөн хуримтлал”-ын дансанд хуримтлуулах ба дансны үлдэгдэлд хүү тооцох юм. 2022 оны 12 дугаар сарын байдлаар 31.6 мянган хүүхэд мөнгөн хуримтлал үүсгэсэн байна. Харин хүүхдийн мөнгөн хуримтлалаас 1,260 мянган хүүхдэд 100.0 мянган төгрөгийг бэлэн мөнгө хэлбэрээр олгосон байна.</p> <p>2023 оны 1 дүгээр сараас нийт хүүхдийн 91 хувь, 7 дугаар сараас Монгол Улсын 0-18 насны бүх хүүхдэд хүүхдийн мөнгийг олгож байна.</p> <p>Хүүхдийн мөнгийг асрамжийн газарт өсч хүмүүжиж байгаа хүүхдүүд хүүхдийн мөнгөний тодорхой хувийг өөрсдийн хэрэгцээт зүйлс, дугуйлан секц зэрэг хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулах</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

						боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг холбогдох журамд тусган 2024 оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна.			
13	2.5.13.Тусгай хэрэгцээ /байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээл/-тэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх боломжоор хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	1	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2020-2024	Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан байна.	Нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг улсын төсвөөс төлсөн байна.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож, тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс бүрэн хариуцахаар эрх зүйн орчин бүрдээд байна. Энэхүү заалтын хэрэгжилт 2024 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхлэх тул Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд хуулийн хэрэгжилтийг хангуулахаар 11.4 мянган хүний шимтгэлд 10.4 тэрбум төгрөгийг тусгуулсан болно.		100
14	2.5.14.Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар мянган ажлын байр шинээр бий болгоно.	1	Эдийн засгийн загварчлалд суурилсан бүтээн байгуулалт, салбар дундын зохицуулалтыг бий болгож, тогтолцоог хөгжүүлнэ.	2020-2024	Загварчлалд суурилсан зохицуулалтыг бий болгосон байна.	Туршилтаар хэрэгжүүлж эхэлсэн байна.	Ажлын байр бий болгох, хадгалах, бичил болон гарааны бизнес эхлүүлэх, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх болон хөнгөлттэй нөхцөлөөр олгох, бусад холбогдох дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах санхүүгийн дэмжлэгийг үзүүлж байна. Нийт 6639 иргэн хамрагдаж, 27,487,543,939 төгрөгийг зарцуулсан. Үүнээс: <ul style="list-style-type: none"> • Иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1958 иргэн хамрагдаж, 16,622,607,700 төгрөгийг; • Малчдыг малжуулах үйл ажиллагаанд 1928 иргэн хамрагдаж, 4,836,503,250 төгрөгийг; • Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл 		90

						<p>ажиллагаанд 685 иргэн хамрагдаж, 619,400,000 төгрөгийг;</p> <ul style="list-style-type: none"> • Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1057 иргэн хамрагдаж, 4,604,100,000 төгрөгийг; • Ажил олгогчийг дэмжих үйл ажиллагаанд 43 иргэн хамрагдаж, 233,710,000 төгрөгийг; • Түрээсийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 956 иргэн хамрагдаж, 561,740,322 төгрөгийг; • Хүүхэд харах үйлчилгээний төвд түрээсийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 12 иргэн хамрагдаж, 9,482,667 төгрөгийг тус тус зарцуулсан байна. <p>Зорилтот бүлгийн иргэд, бичил бизнес эрхлэгчдийн аж ахуй эрхлэх ур чадварыг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, цаашид тогтвортой хадгалах зорилгоор жижиг зээлийг олгож байна. Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд Хаан банк, Төрийн банкаар дамжуулан 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 1402 иргэнд 12,5 тэрбум төгрөгийн зээлийг олгож нийт 2740 ажлын байрыг бий болгосон байна.</p> <p>2023 оноос ХЭДС-ийн өөрийн эх үүсвэрээс /20.0 тэрбум төгрөг/ бага хүүтэй, жижиг зээлийг олгож байгаа бөгөөд хүн амын төвлөрлийг бууруулах, орон нутагт ажлын байр бий болгох, хадгалахыг дэмжих жижиг зээлийг 2023 оны 2 дугаар сараас эхлэн олгож байна. Уг зээлийг аймаг, орон нутагт жилийн 4.4 хувийн хүүтэй Төрийн банкаар, Улаанбаатар хотод жилийн 8.5-8.8 хувийн хүүтэй Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкнуудаар дамжуулан олгож байна.</p> <p>2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт 897 иргэн, 109 аж, ахуйн нэгж байгууллагад 20.9</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

					<p>тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгож 1954 ажлын байрыг бий болгох, хадгалахад дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>Мөн ХХҮЕГ-ын даргын 2023 оны А/76 дугаар тушаалаар финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн санхүүгийн дэмжлэгийг цахимаар дамжуулан олгох санхүүгийн байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдаж сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж Энт кредит инвестмент ББСБ шалгарч ХХҮЕГ-ын 2023 оны ХХҮЕГ/24 тоот гэрээ байгуулан үйлчилгээг Улаанбаатар хот, Дархан-Уул аймагт хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 5356 иргэнд 2,456,690,000 төгрөгийн зээл олгосон байна. Үүнээс Улаанбаатар хотод 4112 иргэнд 1,862,230,000 төгрөг, Дархан-Уул аймагт 1244 иргэнд 594,460,000 төгрөгийн зээл олгосноос 400,000 мянган төгрөгийг 4075 иргэнд, 600,000 төгрөгийг 1015 иргэнд, 800,000 төгрөгийг 252 иргэнд, 1,000,000 төгрөгийг 14 иргэнд олгосон байна. Цаашид Хур болон бусад систем ашиглан иргэн хувиараа хөдөлмөр эрхлэгч гэдэг мэдээллээ оруулан зээлээ шууд судлуулах боломжтой байхаар программ хөгжүүлэлт хийсэн.</p>		
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчдэд олгох жижиг зээлийн хэмжээг нэмэгдүүлж, хугацааг уртасган	2020-2024	Зээлд 1600-аас доошгүй иргэн хамрагдаж, 3000- аас доошгүй ажлын байр бий болсон байна.	Зээлд 1600-аас доошгүй иргэн хамрагдаж, 3000- аас доошгүй ажлын байр бий болсон байна.	<p>Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд журамд жижиг зээлийг 36 хүртэл сарын хугацаатай олгох, үндсэн зээлээс 6 сарын хугацаатай чөлөөлөх, жижиг зээлийн хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0</p>	70	

	хүртээмжийг нэмэгдүүлнэ.				<p>сая хүртэл төгрөг байхаар шинэчлэн баталсан.</p> <p>Хүн амын төвлөрлийг бууруулах, орон нутагт ажлын байр бий болгох, хадгалахыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байна. Үүний дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өөрийн эх үүсвэрээс 20.0 тэрбум төгрөгийн бага хүүтэй, жижиг зээлийг 2023 оны 2 дугаар сараас эхлэн олгож байна. Уг зээлийг аймаг, орон нутагт жилийн 4.4 хувийн хүүтэй Төрийн банкаар, Улаанбаатар хотод жилийн 8.5-8.8 хувийн хүүтэй Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкнуудаар дамжуулан олгож байна.</p> <p>2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт 897 иргэн, 109 аж, ахуйн нэгж байгууллагад 20.9 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгож 1954 ажлын байрыг бий болгох, хадгалахад дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>Тус зээлийг олгох хүрээнд 2023 оны төсвийн төлөвлөлтийг хийхдээ 1 зээлдэгчид 12.0 орчим сая төгрөгийг олгохоор төлөвлөсөн ч зээл хүсэгчдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан бодит дэмжлэг үзүүлэх үүднээс 1 иргэнд ойролцоогоор 20.0 орчим сая төгрөгийг олгосон. Энэ нь тухайн зээл авсан иргэд төслөө бодитой үнэлүүлж, илүү үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн болно. Мөн бид анх удаа орон нутагт хамгийн бага хувийн хүүтэй зээлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон бөгөөд энэ нь тухайн зээлд хамрагдсан иргэдэд илүү боломжийг бий болгож, тооноос илүү чанарт шилжсэн үр дүнг үзүүлсэн.</p>		
3	Зорилтот бүлгийн иргэдийн хувиараа аж ахуй, гарааны бизнес эрхлэхийг	2021-2024	Жил бүр санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлж, зээлд 4500-аас доошгүй иргэн	Жил бүр санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлж, зээлд 4800-аас доошгүй	Ажлын байр бий болгох, хадгалах, бичил болон гарааны бизнес эхлүүлэх, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх болон хөнгөлттэй нөхцөлөөр олгох, бусад холбогдох дэмжлэг үзүүлэх зорилгоор	90	

		<p>дэмжих зорилгоор хүүгүй, барьцаагүй, эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг болон бусад шинэ арга дэмжлэгийг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.</p>		<p>хамрагдаж, 6000-аас доошгүй ажлын байр бий болсон байна.</p>	<p>иргэн хамрагдаж, 7000-аас доошгүй ажлын байр бий болсон байна.</p>	<p>дараах санхүүгийн дэмжлэгийг үзүүлж байна. Нийт 6639 иргэн хамрагдаж, 27,487,543,939 төгрөгийг зарцуулсан. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> • Иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1958 иргэн хамрагдаж, 16,622,607,700 төгрөгийг; • Малчдыг малжуулах үйл ажиллагаанд 1928 иргэн хамрагдаж, 4,836,503,250 төгрөгийг; • Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 685 иргэн хамрагдаж, 619,400,000 төгрөгийг; • Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1057 иргэн хамрагдаж, 4,604,100,000 төгрөгийг; • Ажил олгогчийг дэмжих үйл ажиллагаанд 43 иргэн хамрагдаж, 233,710,000 төгрөгийг; • Түрээсийн болон борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 956 иргэн хамрагдаж, 561,740,322 төгрөгийг; • Хүүхэд харах үйлчилгээний төвд түрээсийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 12 иргэн хамрагдаж, 9,482,667 төгрөгийг тус тус зарцуулсан байна. <p>Зорилтот бүлгийн иргэд, бичил бизнес эрхлэгчдийн аж ахуй эрхлэх ур чадварыг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, цаашид тогтвортой хадгалах зорилгоор жижиг зээлийг олгож байна. Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд Хаан банк, Төрийн банкаар дамжуулан 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 1402 иргэнд 12,5 тэрбум төгрөгийн зээлийг олгож нийт 2740 ажлын байрыг бий болгосон байна. 2023 оноос ХЭДС-ийн өөрийн эх үүсвэрээс /20.0 тэрбум төгрөг/ бага хүүтэй, жижиг зээлийг олгож байгаа бөгөөд хүн амын</p>		
--	--	--	--	---	---	--	--	--

					<p>төвлөрлийг бууруулах, орон нутагт ажлын байр бий болгох, хадгалахыг дэмжих жижиг зээлийг 2023 оны 2 дугаар сараас эхлэн олгож байна. Уг зээлийг аймаг, орон нутагт жилийн 4.4 хувийн хүүтэй Төрийн банкаар, Улаанбаатар хотод жилийн 8.5-8.8 хувийн хүүтэй Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банкнуудаар дамжуулан олгож байна.</p> <p>2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт 897 иргэн, 109 аж, ахуйн нэгж байгууллагад 20.9 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгож 1954 ажлын байрыг бий болгох, хадгалахад дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>Мөн ХХҮЕГ-ын даргын 2023 оны А/76 дугаар тушаалаар финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн санхүүгийн дэмжлэгийг цахимаар дамжуулан олгох санхүүгийн байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдаж сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж Энт кредит инвестмент ББСБ шалгарч ХХҮЕГ-ын 2023 оны ХХҮЕГ/24 тоот гэрээ байгуулан үйлчилгээг Улаанбаатар хот, Дархан-Уул аймагт хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 5356 иргэнд 2,456,690,000 төгрөгийн зээл олгосон байна. Үүнээс Улаанбаатар хотод 4112 иргэнд 1,862,230,000 төгрөг, Дархан-Уул аймагт 1244 иргэнд 594,460,000 төгрөгийн зээл олгосноос 400,000 мянган төгрөгийг 4075 иргэнд, 600,000 төгрөгийг 1015 иргэнд, 800,000 төгрөгийг 252 иргэнд, 1,000,000 төгрөгийг 14 иргэнд олгосон байна. Цаашид Хур болон бусад систем ашиглан иргэн хувиараа хөдөлмөр эрхлэгч гэдэг мэдээллээ оруулан зээлээ шууд судлуулах боломжтой байхаар программ хөгжүүлэлт хийсэн.</p>	
15	4.2.11.Гадаадад сурч, хөдөлмөрлөж	Гадаадад ажиллаж, амьдарч байгаа			<p>-Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит чуулганаар Ажиллах хүчний шилжилт</p>	50

байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно.	1	иргэдийг эх орондоо эргэн ирж ажиллах, хилийн чанадаас улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2024	Хууль эрхзүйн шинэчлэлтэй уялдуулан холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журамд өөрчлөлт оруулж батлуулсан байна	Хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	<p>хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Уг хууль 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Хуулийн 20 дугаар зүйлд Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх заалтуудыг тусгасан. Тухайлбал, 20.1.Эх орондоо буцаж ирсэн монгол ажилтан ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, хөдөлмөр эрхлэхэд хууль тогтоомжид заасны дагуу дэмжих, төсөл, хөтөлбөрт хамруулах дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Энэ хуулийн 20.1-д заасан үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, холбогдох Засгийн газрын тусгай сангийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ.</p> <p>-Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэний эх орондоо буцан ирж хөдөлмөр эрхлэхийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөр батлуулж, хэрэгжилтийг хангана гэж тус тус тусгасан.</p> <p>Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ийг шинэчлэн баталсан бөгөөд журамд жижиг зээлийг 36 хүртэл сарын хугацаатай олгох, үндсэн зээлээс 6 сарын хугацаатай чөлөөлөх, жижиг зээлийн хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөг байхаар шинэчлэн баталсан.</p>		
---	---	---	-----------	---	--	--	--	--

						Мөн ирэх жилээс эхлэн Бүгд Найрамдах Солонгос Улсын холбогдох яамтай хамтран “Хөгжлийн албан ёсны буцалтгүй тусламж/Official Development Assistance-ODA”-аар 2024-2025 онд санхүүжин хэрэгжих “Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэний эх орондоо буцан ирж хөдөлмөр эрхлэхийг дэмжих нь”, төслийг боловсруулан хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.		
	2	Гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эх орондоо эргэн ирж ажиллах, тэдний ур чадварыг нутагшуулахыг бодлогоор дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад хөдөлмөр зуучлалын бирж байгуулна		Хөдөлмөрийн биржийг байгуулж, үйл ажиллагааг туршилтын байдлаар хэрэгжүүлж эхэлсэн байна.	Үйл ажиллагааг бүрэн эхлүүлсэн байна.	Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа Монгол Улсын иргэд эх орондоо чиглэсэн бизнесийн болон сайн дурын үйл ажиллагаа, судалгаа, шинжилгээ хийх, эх нутагтаа эргэн ирж ажиллаж, хөдөлмөрлөхөд дэмжлэг болохуйц Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 онд ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн. “Ejob” платформд гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа Монгол иргэдэд зориулсан сан бүхий хэсэг, хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ (профайлинг) модуль хэсгийг шинэчлэн хөгжүүлж, цахим өдөрлөг яармаг зохион байгуулах зэрэг эх орондоо эргэн ирж ажиллах нөхцөл бололцоог ханган ажилд зуучлах, ажил хайх үйлчилгээг онлайн хэлбэрээр авч болохоор программ хангамжийн хөгжүүлэлт хийгдсэн болно. 2023 оны 12 дугаар сарын байдлаар “Ejob” платформд Бүртгэлтэй ажлын байрны тоо–70293, Ажил хайгчийн тоо–87466, Ажил олгогчийн тоо–12063, Ажилд зуучлагдсан иргэдийн тоо–19962, Мобайл аппликэйшн хэрэглэгчийн тоо-29065 болсон байна. Мөн ирэх жилээс эхлэн Бүгд Найрамдах Солонгос Улсын холбогдох яамтай хамтран “Хөгжлийн албан ёсны буцалтгүй тусламж/Official Development Assistance-ODA”-аар 2024-2025 онд санхүүжин хэрэгжих “Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэний эх орондоо буцан ирж хөдөлмөр эрхлэхийг дэмжих нь”, төслийг		90

						боловсруулан хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.			
17	4.2.5.Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана		Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	2021-2024	Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна.	Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг хагас бүтэн жилээр үнэлэн ёс зүйн зөрчил гарган, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдыг үр дүнгийн урамшууллаас хасах арга хэмжээ авч ажиллалаа. Мөн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчдын ёс зүйн хэмжээ, ёс зүйн шаардлага, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх сахилга хариуцлагыг чангатгах зүйл, заалтыг нарийвчлан тусгалаа. Мөн байгууллагын Ёс зүйн зөвлөлийн гишүүдэд өөрчлөлт оруулж, зөвлөлийн үйл ажиллагааг албан хаагчдад ёс зүй, сахилга хариуцлагын нөлөөллийн болон сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулахад анхаарч ажиллаж байна.		70
18	4.3.5.Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.	2	Эмэгтэйчүүдийг бэлгийн дарамтад өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	2020-2025	Төлөвлөгөө батлагдахаас өмнөх оны байдлыг төлөвлөгөө батлагдсанаас хойшхи хэрэгжилттэй харьцуулан үр дүнг тооцно.	214,6 сая.төг дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлээд байна	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас БНСУ-ын Жендэрийн тэгш эрх, гэр бүлийн яамтай хамтран “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх” төслийг 5 жилийн хугацаатай амжилттай хэрэгжүүлж дууслаа. Энэхүү төсөл нь хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх замаар холбогдох бодлого, хөтөлбөрт нөлөөлөх, хэрэгжилтэд олон талт оролцоог нэмэгдүүлэх үндсэн зорилгын хүрээнд хэрэгжсэн. Төслийн гүйцэтгэгч байгууллагаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах чиглэлээр 2000 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа Хүйсийн тэгш эрх төв ТББ ажиллалаа.		100

						<p>Төслийн хаалтын үйл ажиллагааг 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр олон салбарын төлөөллийг оролцуулсан бага хурал хэлбэрээр зохион байгуулж, мөн уран бүтээлчдийн дунд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зарласан уран бүтээлийг шалгаруулж, шалгарсан бүтээлээр үзэсгэлэн гаргаж, олон нийтийн хүртээл болголоо.</p> <p>Тус бага хуралд Бүгд Найрамдах Солонгос Улсаас ирсэн төлөөлөл, Соёлын яам, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Цагдаагийн байгууллага, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, болон дүүргүүдийн сургалтад хамрагдсан алба хаагчид, даван туулагчид, Олон Улсын байгууллага, төрийн бус байгууллагын нийт 60 гаруй төлөөлөл оролцлоо.</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

Арга хэмжээний биелэлт 81.5%

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ